



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРОО

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон  
Сүхбаатарын тэгбай 8, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathuru@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2023.01.23 № УИХ-04/659

танаи \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ Г

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын  
“Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө  
оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн еренхий  
хэлэлцээрийн тесслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй  
байдал, гадаад бодлогын байнгын хороо, Төсвийн болон  
Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт,  
хуралдааны тэмдэглэлийг тус тус хүргүүлж байна.

Хавсралт 5 хуудастай.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

2023000060



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 01 сарын 19-адар

Дугаар 03

Улаанбаатар хот

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааны тэмдэглэл:

**ХЭЛЭЛЦСЭН нь:**

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хороондын "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хетэлбөр"-ийн Санхүүжилтийн еренхий хэлэлцээрийн төслийг зөвшилцэх.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хороондын "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хетэлбөр"-ийн Санхүүжилтийн еренхий хэлэлцээрийн төслийг дэмжиж, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгов.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

БАЙНГЫН ХОРОО  
ХАРИУЦСАН РЕФЕРЕНТ

Б.ГАНДИЙМАА

**МОНГОЛ УЛС, АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНДЫН "АЙМАГ, СУМЫН  
БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР"-ИЙН  
САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨН  
ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 01 дүгээр  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцехеөр ирүүлсэн Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн еренхий хэлэлцээрийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Дээрх төслийн зөвшилцех асуудлыг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд тус тус ирүүлсэн болно.

Тус Байнгын хорооны хуралдаанаар уг төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр хэлэлцээрийн төсөлд туссан хөдөө аж ахуйн салбарын ногоон санхүүжилтийг дэмжих, бэлчээрийн менежментийг сайжруулах, хяналтын тогтолцоог бурдүүлэхэд зээлийн хөрөнгийг зарцуулах нь оновчтой эсэх, мал аж ахуйг эрчимжүүлэх, эрчимжсэн газар, тариаланг хөгжүүлэх, зоорь барих, эрчим хүчний асуудал, төмөр замыг цахилгаанжуулах зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд анхаарч, төслийн зориулалтыг зөв тодорхойлж, үр ашигтай төсөл, хетэлбөрт зээлийн санхүүжилтийг зарцуулах боломжтой эсэхийг тодруулан асуусан бөгөөд манай улсын гадаад өрийн хэмжээ их байгаа энэ үед авч байгаа зээлийн хөрөнгийг эм, эмнэлгийн чанар, хүртээмжийг сайжруулах, боловсрол, эрчим хүчний салбарт тодорхой хөрөнгө оруулах, ажлын байрыг бий болгох, бүтээмжийг дээшлүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, аж ахуйн нэгжүүддээ төрөөс бодлогоор бага хүүтэй, урт хугацаатай зээл олгох, уул уурхайн салбар болон түүхий эдийн боловсруулалт, хөгжилдээ зориулдаг байх хэрэгтэй гэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан хэлэлцээрийн төслийг дэмжих байгаагаа илэрхийлээд, "Бэлчээр ашиглах гэрээ" гэсэн томьёоллыг энэхүү төсөлд тусгасан нь байгаль, цаг уурын нөхцөлөөс шууд хамааралтай нүүдлийн мал аж ахуйн өв соёлыг алдагдуулах, нүүдэл хийж айл, саахалтаараа бууж амьдардаг уламжлалт мал аж ахуйн зориулалттай бэлчээрийг малчин иргэн, эсхүл "малчдын бүлэг" гэрээгээр зохицуулах нь малчдын дунд бэлчээрийн асуудлаар маргаан, зерчил үүсгэх эрсдэлтэй бөгөөд Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д заасан "үндэсний эв нэгдлийг эрхэмлэх" гэсэн заалттай зөрчилдэж байгаа учраас анхааралдаа авах, түүнчлэн бэлчээрийн даацад малын тоо толгойг тохируулах, сүргийн тоо, толгойг цөөрүүлэх зэрэг үйлдэл нь малчин өрхүүд төв орон нутаг руу нүүх, төвлөрсөн амьдрал руу шилжин суурьших шалтгаан болох эрсдэлтэйг ажлын хэсэгт анхаарууллаа.

Тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө

оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн төслийг зөвшилцөх тухай асуудлыг дэмжсэн болно.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



A handwritten signature in black ink, appearing to read "Б.ЭНХ-АМГАЛАН".

Б.ЭНХ-АМГАЛАН

**МОНГОЛ УЛС, АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНДЫН “АЙМАГ, СУМЫН  
БУСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТЕЛБӨР”-ИЙН  
САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨХ  
ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттемэр**

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хороондын “Аймаг, сумын бусчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн төслийг Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдөр ирүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа дээрх хэлэлцээрийн төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Төсөл санаачлагчийн зүгээс энэхүү хөрөнгө оруулалтын хөтөлбөреөр хөдөө аж ахуйн салбарын ногоон санхүүжилтийг дэмжих, бэлчээрийн менежментийг сайжруулах, түүнийг хянах тогтолцоог бурдүүлэх, хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ, үйл ажиллагаануудыг 15 аймаг, 34 сумын нийт 49 байршил дээр хэрэгжүүлэхээр төлөвлөснийг дурдсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, М.Оюунчимэг, О.Цогтгэрэл хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх байршилуудын талаар, зээлийн зориулалтыг хэрхэн хуваарилсан талаар, олон улсын төсөл, хөтөлбөреөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн үр дүнгийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд олон улсын байгууллагуудаас төсвийн алдагдлыг нөхөх, валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр бага хүйтэй, урт хугацаатай зээл, буцалтгүй тусламж, төсөл хөтөлбөрийг хангалттай авч, үр дүнтэй хэрэгжүүлэх, зарцуулах нь зүйтэй гэсэн саналыг хэлсэн болно.

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хороондын “Аймаг, сумын бусчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлаар санал хураахад Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



Ц.ЦЭРЭНПҮНЦАГ

**МОНГОЛ УЛС, АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНДЫН "АЙМАГ, СУМЫН  
БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТЕЛБӨР".  
ИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙН  
ЗӨВШИЛЦӨХ ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 01 дүгээр  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан**

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд зэ.

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хороондын "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөренгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн төслийг 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа дээрх төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Төслийн хүрээнд хөдөө аж ахуйн бизнесийн хөренгө оруулалтыг хэрэгцээт газар нь хүргэхэд учирч буй саад бэрхшээлийг багасгах, улсын хэмжээнд эдийн засаг, уул уурхайгаас хэт хамааралтай байдлыг бууруулах, эдийн засгийн төрөлжилтийг дэмжихэд шаардлагатай хүчин зүйлс буюу орон нутгийн хөгжил, ажлын байр нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ гэж төлөвлөсөн байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хэлэлцүүлгийн явцад бүх аймгууд болон алслагдсан гурван дүүргийг хамруулах нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар зээлийн хэлэлцээрийн хэрэгжилт, зарцуулалтад онцгой анхаарч мэргэжлийн байгууллагуудын оролцоог хангаж ажиллах нь зүйтэй гэсэн саналуудыг тус тус гаргасан болно.

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хороондын "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөренгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн төслийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцэхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд зэ,

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хороондын "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөренгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн төслийг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

**Ж.БАТЖАРГАЛ**